

**ОРХОН АЙМАГ**

# **ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ДЭД ХӨТӨЛБӨР**

Хөтөлбөр боловсруулсан: Ч.Мөнхзул

**2019 ОН**

## АГУУЛГА

### 0. Танилцуулга

.....

### 1. Нийтлэг үндэслэл

.....

### 2. Дэд хөтөлбөрийн зорилго

.....

### 3. Дэд хөтөлбөрийн зорилт

.....

### 4. Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

.....

### 5. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

.....

### 6. Дэд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэл

.....

### 7. Дэд хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө

.....

### 8. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

.....

### 9. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

.....

**ОРХОН АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧ  
ХЭМНЭХ ДЭД ХӨТӨЛБӨР  
(2019-2022 он)**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

Аймгийн хэмжээнд эрчим хүчийг хэмнэж зөв зохистой хэрэглэх, дулааны алдагдлыг бууруулах нь эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлтийн үр ашиг сайжрах, орон нутгийн эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ажил, үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, ард иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад орших юм.

Орхон аймгийн хувьд 2 сумтай ба Баян-Өндөр, Жаргалант сумдын нийт хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүч, дулаанаар тасралтгүй найдвартай хангах үүргийг хүлээсэн эрчим хүчний төрийн болон орон нутгийн өмчит компаниуд ажиллаж байна. Эдгээр компаниудтайгаа хамтран Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нийтэд сурталчилах, алдагдлыг бууруулж, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор боловсруулсан Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд энэхүү дэд хөтөлбөрийг боловсрууллаа.

**1. ЭБЦТС ТӨХК**

Компанийн эзэмшил үйлчилгээний заагийн хойд тал нь Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум, урд тал нь Өмнөговь аймгийн Мандал-Овоо, зүүн тал нь Төв аймгийн Бүрэн, баруун тал нь Завхан аймгийн Их-Уул сум хүртэлх 385000 км кв газар нутагт, Монгол орны 11 аймгийн 121 сум, суурин газрын 7143 ААН, 68871 айл өрх, нийт 76014 хэрэглэгчид цахилгаан эрчим хүчийг түгээж байна.

Жилд дунджаар 1 тэрбум кВтц цахилгаан эрчим хүчийг түгээж, 180 гаруй тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилладаг. Бүтэц зохион байгуулалтын хувьд Архангай, Булган, Өвөрхангай, Хархорин гэсэн орон нутгийн 4 салбар, төвдөө Захиргаа хүний нөөцийн, Техникийн бодлогын, Борлуулалтын бодлого зохицуулалтын, Шинэчлэл инноваци хөгжлийн, Дотоод хяналт аюулгүй ажиллагааны, Санхүү эдийн засаг бүртгэлийн, Хангамж үйлчилгээний гэсэн 7 хэлтэст харьяалагдах 643 ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

## Орхон аймгийн хувьд:



Тус компани нь Монгол улсын эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу “Шинэ эрчим инженеринг” ХХК-аар эрчим хүчний хэмнэлтийн аудитыг хийлгэн, заавар зөвлөмжийн дагуу болон Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.108-д “Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх, алдагдал бууруулах, инновацийн түвшний шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” гэж заасныг үндэслэн “ЭБЦТС” ТӨХК нь 2018-2022 он хүртэл хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан дараах Зорилго, Зорилтуудыг тавин ажиллаж байна.

- Хөтөлбөрийн зорилго:

Эрчим хүч хэмнэх, үр ашигтай түгээх, хэрэглэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган уялдуулах, эрчим хүчний хэмнэлттэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, хэрэглэх үндсэн дээр инженер эдийн засгийн тооцоо судалгааг хийж, Засгийн газрын 2016 оны 294 тогтоолоор баталсан Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго оноо болох түгээлтийн алдагдлын жилийн хэмжээг 9%-иас доош оруулах, дотоод хэрэгцээний цахилгаан дулааны эрчим хүчний хэмжээг бууруулахад оршино.

- Хөтөлбөрийн зорилт:

- Компанийн хэмжээнд эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг сайжруулах
- Эрчим хүчийг хэмнэх үйл ажиллагааг уялдуулсан, үр ашигтай хэрэглээг дэмжсэн удирдлага, мэдээллийн системүүдийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх
- Эрчим хүч хэмнэх, эрчим хүчний хэмнэлттэй технологийг эрчимжүүлж, хэрэглэгчид, үйлдвэрлэгчдэд мэдээлэл, боловсрол, харилцааны компанит ажил явуулах замаар эрчим хүчний хэмнэлтийг эрчимжүүлэхэд түлхэц үзүүлэх
- Хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний зөв зохистой хэрэглээний талаар сурталчилгаа хийх
- Эрчим хүчний үр агшийг дээшлүүлэх хөтөлбөрийг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хэрэгжүүлэхэд бусад компаниудтай хамтран ажиллах хүчин чармайлтыг эрчимжүүлэх
- Эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, үнэлэхэд техникийн туслалцаа үзүүлэх

## **2. ЭРДЭНЭТ УС, ДТС ОНӨХК**

“Эрдэнэт Ус, ДТС” ОНӨХК Орхон аймгийн нийт 93000 хүн амын 90 орчим мянган хүнд цэвэр усаар хангаж, үүнээс Эрдэнэт хотын орон сууцны 345 байрны оршин суугч 11016 орчим өрхийн 25280 хүн ам 1016 аж ахуйн нэгжийг цахилгаан дулааны эрчим хүчээр хангаж, цэвэр ус түгээх, бохир ус татан зайлуулж, жил бүр тодорхой төсөвт хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж байна. Мөн түүнчлэн орон сууцны айл өрхийн сантехникийн засвар үйлчилгээ хийх 24 цагийн тасралтгүй ажиллагаатай диспетчерийн үйлчилгээ, Жаргалант, Баян-Өндөр сумын гэр хорооллын айл өрхүүдийн усан хангамж, Жаргалант сумын төвлөрсөн усан хангамж, Орон сууцны

байрнуудын цахилгаан шатны ашиглалт, засвар үйлчилгээ, Хотын төв болон багуудын авто замын дагуух гэрэлтүүлгийн ашиглалт, засвар үйлчилгээ, нийтийн халуун усны үйлчилгээг тус тус үзүүлж байна. Манай компани нь нийт 322 ажиллагсадтай. Инженер, эдийн засгийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Усан хангамжийн алба, Ариутгах татуургын алба, Диспетчерийн шуурхай үйлчилгээний алба, Борлуулалтын алба, Дулаан түгээх сүлжээний алба, Цахилгааны алба, Барилга, засвар техник үйлчилгээний алба, Ус цахилгааны тоолуурын лаборатори гэсэн бүтэц зохион байгуулалттай ажиллаж байна.

ЭРДЭНЭТ УС, ДТС ОНӨХК-нь 2018-2020 он хүртэл хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулан дараах Зорилго, Зорилтуудыг тавин ажиллаж байна.

- **Хөтөлбөрийн зорилго:**

Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ЦЭХ-ний зарцуулалт өндөртэй насос, тоног төхөөрөмжүүдийг орчин үеийн шинэ техник технологиор солих, нэвтрүүлэх замаар эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аюулгүй байдлыг бүрэн хангасан, байгаль орчинд ээлтэй, үр ашигтай хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд гол зорилго оршино.

- **Хөтөлбөрийн зорилт:**

Эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 2018-2020 оны 3 жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан ажиллана. Үүний дагуу дараах үндсэн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Өөрийн хэрэгцээнд ашиглагдаж байгаа насосуудын ЦЭХ-ний зардлыг хамгийн бага байхаар горим ажиллагааг тохируулж, тоноглолууд суурилуулах
- Дулаан хуваарилах төвүүдэд дулааны тоолуур суурилуулж дуусах, ЭХЗХ-оос худалдан авах дулааны бөөний тариф батлуулах
- Гэр хороололд гарч байгаа ЦЭХ-ний зүй бус алдагдлыг бууруулж, борлуулалтын бичилтийг 90%-д хүргэх
- Гэрэлтүүлэг шинэчлэх
- Ус, цахилгаан, дулааны ухаалаг тоолуурыг үе шаттайгаар нэвтрүүлэх
- Цэвэр усны зүй бус алдагдлыг бууруулах ажлыг зохион байгуулах
- Байгууллагын хэмжээнд ашиглаж байгаа 25 автомашинд GPS суурилуулах
- Объектуудыг камержуулах

- Давтамж хувиргуурыг мэдрэгчүүдийн тусламжтайгаар автомат тохиргоогоор удирдах

### **3. “ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК**

Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц нь 7 зуух, 3 турбинтэй, цагт 302.5 Гегакалори/цаг дулаан, 28,8 Мегаватт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх чадалтай бөгөөд 1 алба, 4 хэлтэс, 8 цехийн зохион байгуулалттай, 433 хүнтэйгээр, 24 цаг тасралтгүй үйл ажиллагаа явуулан ажиллаж байна.

“Эрдэнэтийн Дулааны цахилгаан Станц” Төрийн өмчит хувьцаат компани нь жилд дунджаар 154,6 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 123,3 сая кВтц цахилгаан эрчим хүч түгээдэг.

*Эдгээр компаниудын зориго, зорилтын хүрээнд болон орон нутагтаа хэрэгжүүлэх “Эрчим хүчний дэд хөтөлбөр”-ийг боловсруулан гаргалаа.*

#### **Хоёр.Дэд хөтөлбөрийн зорилго**

##### *2.1.Дэд хөтөлбөрийн зорилго:*

Орхон аймгийн хэмжээнд эрчим хүчийг зөв зохистой ашиглах, цахилгаан, дулаан хангамжийн системийн үр ашгийг нэмэгдүүлэх, хэмнэх, алдагдлыг бууруулж, шинэ техник, технологи суурилуулах ашиглах, байгаль орчны болон агаарын бохирдлыг бууруулахад энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

#### **Гурав.Дэд хөтөлбөрийн зорилт**

*3.1.Дэд хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:*

3.1.1.Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлох;

3.1.2 Орон нутгийн харьяа эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд явуулах хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх;

3.1.3.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж компани байгууллагуудад эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.4.Орон нутгийн иргэд, олон нийтэд эрчим хүчний хэмнэлтийг сурталчлах ажлыг зохион байгуулах, орон нутгийн боловсролын байгууллагуудтай хамтран

ерөнхий боловсролоор дамжуулан эрчим хүчний хэмнэлт-зохистой хэрэглээнд хүүхдүүдийг сургах, төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлэх;

3.1.5.Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрчим хүчний хэмнэлттэй байдлаар төлөвлөх, орон нутгийн мэргэжлийн хяналт, шалгалтын нэгжээр дамжуулан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хяналт тавих замаар эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай байлгах;

3.1.6.Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах;

3.1.7. Жаргалант суманд шинээр уурын зуух барьж ашиглалтанд оруулах

3.1.8. Дэнж Эрдэнэ багийн шинэ суурьшлын бүсэд 160кВа дэд өртөө, 6/0,4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих

3.1.9. Яргуйт багийн шинэ суурьшлын бүсэд 0,4/0,22 кВ-ын ЦДАШ барих

3.1.10. Орхон аймгийн инженерийн шугам сүлжээний засвар шинэчлэлтийг үе шаттайгаар цаашид үргэлжлүүлэх

3.1.11. Хуучин цахилгаан, дулааны алдагдалтай гэрэл, цонх, хаалгануудыг шинэчлэн солих

### **Дөрөв.Дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

*4.1.“Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх үндсэн чиглэлүүдийг тодорхойлох” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.1.1.Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох газар, хэлтэс, агентлаг, мэргэшсэн хувийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

4.1.2.Төсвөөс санхүүждэг орон нутгийн байгууллагуудын бүртгэлийг хийх, тэдгээр байгууллагуудад эрчим хүчний үр ашиг, хэмнэлтийн ажлыг зохион байгуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

*4.2.“Орон нутгийн харьяа эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд явуулах хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.2.1.Эрчим хүчний үйлдвэрлэл түгээлтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

4.2.2.Их болон урсгал засварыг эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай тоног төхөөрөмжөөр хийж гүйцэтгэх;



4.2.3. Дулааны эрчим хүчний хэрэглээг тоолуураар тооцох үндсэн нөхцлийг бүрдүүлэх, үнэ, тарифыг бодит өртөгт тулгуурлан тогтоох;

4.2.4. Эрчим хүчийг тоолуураар борлуулах үйл ажиллагааг идэвхижүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шаардлага тавьж ажиллах;

4.3. *“Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж компани байгууллагуудад эрчим хүчний хэмнэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.3.1. Төсөвт байгууллагуудын дулааны хэрэглээг тоолууржуулах ажлыг хэрэгжүүлэх, тоолуурын заалтаар төлбөр тооцоог хийдэг болох;

4.3.2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж компани байгууллагуудын барилга байгууламжид дулааны алдагдлыг хэмжиж, дулаалах шаардлагатай барилгыг тодорхойлж үе шаттай арга хэмжээ авах;

4.3.3. Гудамж, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлгийн системийг сайжруулах /Эрчим хүчний хэмнэлттэй лед гэрэл гэх мэт/;

4.4. *“Орон нутгийн иргэд, олон нийтэд эрчим хүчний хэмнэлтийг сурталчлах ажлыг зохион байгуулах, орон нутгийн боловсролын байгууллагуутай хамтран ерөнхий боловсролоор дамжуулан эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээнд хүүхдүүдийг сургах, төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.4.1. Орон нутагт эрчим хүч хэмнэх өдөрлөг, үзэсгэлэн зохион байгуулж иргэд олон нийтэд нээлттэй мэдээ мэдээлэл өгөх, ажлыг зохион байгуулах. /Эрчим хүчний хэмнэлттэй бараа, барилгын материал, дулааны тусгаарлагын материал зэрэг/ гэх мэт;

4.4.2. Орон нутгийн боловсролын байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулиудаас Эрчим хүч хэмнэлтийн сургагч багш бэлдэх, бага болон дунд ангийн хүүхэд багачуудад эрчим хүч хэмнэх зохистой хэрэглээг хэвшүүлэх;

4.4.3. Орон нутгийн телевиз, радио fm, веб сайтаар дамжуулан эрчим хүч хэмнэх видео, бичлэг гэх мэт ажлыг зохион байгуулах, түгээх;

4.5. *“Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг эрчим хүчний хэмнэлттэй байдлаар төлөвлөх, орон нутгийн мэргэжлийн хяналт, шалгалтын нэгжээр дамжуулан хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хяналт тавих замаар эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай байлгах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.5.1.Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт үр ашгийн тооцоо хийлгүүлж хэвших, эрчим хүчний хэмнэлттэй байдлаар төлөвлөж хийлгүүлэх, хэрэгжилтийг хянах;

4.5.2.Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээнд мэргэжлийн хяналт,шалгалтын нэгжээр эрчим хүчний хэмнэлттэй эсэхэд хяналт тавьж ажиллах;

*4.6.“Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:*

4.6.1. Аймаг, сумын Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

4.6.2. Аймаг, сумын Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар орон нутгийн бодлогыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

4.6.3. Аймаг, сумын Засаг дарга эрчим хүч хэмнэлтийн талаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлэх;

### **Тав.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа**

*5.1.Дэд хөтөлбөрийг 2019-2022 онд хэрэгжүүлнэ.*

### **Зургаа.Дэд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт**

*6.1.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:*

6.1.1.Орон нутгийн эрчим хүчний хэрэглээнд гол байр суурь эзэлдэг том аж ахуйн нэгжийн бүртгэл хийж, барилгын болон эрчим хүчний үндсэн судалгаа хийгдсэн байна. (Бүртгэлд гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалттай байгууллагуудыг бүгдийг хамруулна )

6.1.2.Эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлтийн үр ашиг сайжирсан байна.

6.1.3.Их болон урсгал засварын ажлыг Эрчим хүчний үр ашигтай материал, тоног төхөөрөмжөөр шийдэж, дулааны алдагдал бууруулах ажил хийгдсэн байна.

6.1.4.Орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид дулааны тоолуурын тарифтай болсон байна.

6.1.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үнэ, тарифт тоолууржуулах ажлын зардлыг шат дараалан тусгаж тоолууржуулах ажил үе шаттай хэрэгжсэн байна.

6.1.6.Гэрэлтүүлгийн цахилгааны эрчим хүчний зардал хэмнэнэ.

6.1.7.Орон нутгийн боловсролын байгууллагатай хамтран Эрчим хүч хэмнэлтийн сургагч багштай болсон байна. Сурагчдад эрчим хүч хэмнэх зохистой хэрэглээний талаар мэдэгдэхүүнийг батлагдсан хөтөлбөрийн дагуу өгсөн байна.

6.1.8.Эрчим хүч хэмнэх ажлын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооноос бэлдсэн видео бичлэг,шторк, зурагт хуудас зэргийг олонд түгээх ажлыг эхлүүлсэн байна.

6.1.9.Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт үр ашгийн тооцоо хийгдсэн, эрчим хүчний хэмнэлтийн арга хэмжээнүүд авагдсан байна.

6.1.10.Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хяналт, дүгнэлт гаргуулсан байна.

6.1.11.Төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнд эрчим хүчний хэмнэлт гарсан байна.

6.1.12.Жил бүрийн эхний улиралд багтаан орон нутагт хийгдсэн эрчим хүчний хэмнэлтийн ажлын тайланг Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлнэ.

6.1.13.Барилгын дулааны алдагдал буурна.

6.1.14. Цахилгаан эрчим хүчний алдагдал тодорхой хэмжээгээр буурна.

6.1.15. Хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний хангамжийн найдваржилт дээшилнэ

6.1.16.Шугам сүлжээ, тоног төхөөрөмжид гарах тасралт багасаж, засварын зардал үлэмж хэмжээгээр багасна.

6.1.17.Хэрэглэгчид хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ хэрэглээг хянах, зүй зохистой хэрэглэх боломж бүрдэнэ.

6.1.18.Гэр хорооллын айл өрхүүд шөнийн тарифын хөнгөлөлтөд бүрэн хамрагдана.

6.1.19.Хангагч хэрэглэгчийн хоорондын хамтын ажиллагаа сайжирна.

### **Долоо.Дэд хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгө**

*7.1.Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:*

7.1.1. Орон нутгийг хөгжүүлэх сан (жил бүр 5 хүртэл хувь);

7.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

7.1.3. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;

- 7.1.4. банк, санхүүгийн байгууллагын хөнгөлөлттэй зээл;
- 7.1.5. олон улсын байгаль хамгаалах сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт;
- 7.1.6. бусад эх үүсвэр.

### **Найм.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

8.1.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, салбар дундын бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс хариуцан гүйцэтгэнэ.

8.2. Ажлын хэсэг байгуулах, сумдыг татан оролцуулах;

8.3.Аймгийн хэмжээнд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг аймгийн Засаг дарга, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлтэй хамтран гүйцэтгэнэ.

### **Ес.Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**

9.1.Орон нутгийн хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг дарга, Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Эрчим хүчний зохицуулах зөвлөлтэй хамтран гүйцэтгэж тайлангаа Эрчим хүч хэмнэлтийн зөвлөлд хүргүүлнэ.

9.2.Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

-----oO-----